



## НИЙСЛЭЛИЙН БИЕЙН ТАМИР СПОРТЫН ГАЗРЫН ДАРГЫН ТУШААЛ

2013 оны 10 сарын 01 өдөр

Дугаар A/57

Улаанбаатар хот

### Нийслэлийн Иргэдийн спортын II их наадмын олс таталтын тэмцээн зохион байгуулах тухай

Монгол Улсын Биеийн тамир, спортын тухай хуулийн 10 дугаар зүйл, Засгийн газрын 2005 оны 246, 2009 оны 05 дугаар тогтоолууд, Нийслэлийн Засаг дарга бөгөөд Улаанбаатар хотын захирагчийн мөрийн хөтөлбөр, 2013 оны эдийн засаг, нийгмийн зорилт, Нийслэлийн Засаг даргын 2013 оны А/333 дугаар захирамжийг үндэслэн ТУШААХ нь:


1. Нийслэлийн иргэдийн спортын II их наадмын олс таталтын тэмцээнийг 2013 оны 11 дүгээр сарын 02-ны өдөр Нийслэлийн Засаг даргын Тамгын газрын спорт зааланд зохион байгуулсугай.

2. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах төсвийг нэгдүгээр, шүүгчдийн бүрэлдэхүүнийг хоёрдугаар хавсралтаар тус тус баталсугай.

3. Тэмцээнийг зохион байгуулахад шаардагдах 1.138.000 /нэг сая нэг зуун гучин найман мянга/ төгрөгийг Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын орон нутгийн төсвийн иргэдийн спортын наадмын зардлаас гаргахыг нягтлан бодогч О.Эрдэнэцэцэгт зөвшөөрсүгэй.


4. Тэмцээний урьдчилсан бэлтгэлийг сайтар хангаж, зохион байгуулалтын өндөр хэмжээнд явуулахыг мэргэжилтэн Б.Түвшинбаярт үүрэг болгосугай.

ДАРГА



Ж.ГАНБОЛД

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2013 оны аравдугаар сарын 01-ны өдрийн  
А/Б/Г дугаар тушаалын нэгдүгээр хавсралт



Нийслэлийн иргэдийн спортын II их наадмын  
олс таталтын тэмцээний төсөв

№	Зардлын нэр	Нийт дүн
1.	Тамирчдын шагнал: 1-р байр 16 хүн x 10.000₮ = 160.000 2-р байр 16 хүн x 8.000 ₮ = 128.000 3-р байр 32 хүн x 6.000 ₮ = 192.000	480.000 төг
2.	Шүүгчдийн ажлын хөлс: /6 хүн x 1 өдөр x 15.000₮/	90.000 төг
3.	Медалийн үнэ:	288.000 төг
4.	Заал талбайн хөлс	200.000 төг
5.	Цом/анонс/	80.000 төг
	Дүн	1.138.000 төг

Боловсруулсан  
Хянасан

Б.Түвшинбаяр  
О.Эрдэнэцэцэг

Нийслэлийн Биеийн тамир, спортын газрын даргын  
2013 оны *аравдугаар* сарын *01*-ны өдрийн  
*А/57* дугаар тушаалын хоёрдугаар хавсралт

Нийслэлийн иргэдийн спортын II их  
наадмын олс таталтын тэмцээний  
шүүгчдийн бүрэлдхүүн

- |                       |               |
|-----------------------|---------------|
| 1. Ерөнхий шүүгч      | Б.Адьяахүү    |
| 2. Нарийн бичиг шүүгч | Б.Билэгжаргал |
| 3. Шүүгч              | Ж.Төгөлдөр    |
| 4. Шүүгч              | С.Манжаа      |
| 5. Шүүгч              | Б.Билгүүн     |
| 6. Шүүгч              | Б.Өсөхбаяр    |